



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Ховд аймгийн Нийгмийн даатгалын нэгтгэсэн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас:70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Аудитор: Ц.Аззаяа  
Утас: 99125777  
цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	12
3.5.3 Нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.БАТЧУЛУУН ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 02/90

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн Green Finance системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хөгжүүлж тайлант жилийн туршид нягтлан бодох бүртгэл хөтөлж, 12 удаагийн мэдээ болон 2022 оны хагас, бүтэн жилийн тайлан гаргасан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар цахим архивын тоног төхөөрөмж хүлээн авч тус хэлтэс дээр хадгалагдаж байгаа 4871 тэтгэврийн хувийн хэрэг болон архивын 6000 орчим боть баримт материалыг алсын зайн радио долгион бүхий соронзон чипээр чипэлж, холбогдох тоног төхөөрөмж, программ хангамжийг суурилуулан ажилласан байна. Ингэснээр баримт материалын хадгалалт, хамгаалалт сайжирч лавлагаа мэдээлэл гаргах ажиллагаа 4-5 дахин буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол улсын засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож уг тогтоолыг хэрэгжүүлэхэд 350.0 мянгаас дээш төгрөгийн тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг тэтгэврийн доод хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд нэмэгдлийн хэмжээ нь 15 хувьд хүрэхгүй байгаа иргэдийн авч байгаа

тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэхээр тогтоол гарсантай холбогдуулан 2022 оны 2 дугаар сарын тэтгэврийг нэмэгдсэн хэмжээгээр олгох ажлыг шуурхай зохион байгуулан нийт 12480 тэтгэвэр авагчдад 1,626.0 сая төгрөгийн нэмэгдлийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр бүрэн хийж тэтгэвэр авагчдад олгосон. Үүнээс 7067 тэтгэвэр авагчдад 150.0 мянган төгрөг, 3836 тэтгэвэр авагчдад 15 хувиар, 1577 тэтгэвэр авагчдад хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр нэмэгдүүлсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус хэлтэс нь 2022 онд нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай 4 зорилт 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон ерөнхий газарт хүргүүлж 99.5 хувьтай буюу "маш сайн" үнэлэгдсэн байна.

Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Хаан банк, Хас банк, Голомт банк, Төрийн банк нийт арилжааны 4 банктай 2022 онд "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан биелэлтийг хагас болон бүтэн жилээр дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт дүн мэдээг хүргүүлэн ажиллажээ.

Хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/15, 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/33 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын дагуу "Тэтгэвэр тогтоож, олгох үйлчилгээний заавар"-ын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж шалгаж баталгаажуулжээ. Тооллогод 17 сумын 13759 тэтгэврийн хувийн хэрэг хамрагдсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,052,911,828.8</b>	<b>15,435,877,561.6</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,485,991,960.6</b>	<b>8,075,171,176.7</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,485,991,960.6</b>	<b>8,075,171,176.7</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>6,485,991,960.6</b>	<b>8,075,171,176.7</b>
31211	Төрийн сангийн харилцах	83,885,391.9	102,600,876.6
31213	Арилжааны банк дахь харилцах	6,402,106,568.7	7,972,570,300.2
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>7,563,148,988.2</b>	<b>7,356,285,574.9</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	904,112,058.3	1,573,038,284.4
33300	Татаас, санхүүжилтийн авлага	6,609,950,696.1	5,675,028,606.1
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>49,086,233.8</b>	<b>108,218,684.4</b>
33510	Байгууллагаас авах авлага	49,086,233.8	108,218,684.4
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,770,880.0</b>	<b>4,420,810.0</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,770,880.0</b>	<b>4,420,810.0</b>
35410	Бичиг хэргийн материал	0.0	20,550.0
35420	Аж ахуйн материал	3,314,150.0	3,684,150.0
35470	Бусад хангамжийн материал	456,730.0	716,110.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,284,211,778.7</b>	<b>1,340,518,592.6</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,284,211,778.7</b>	<b>1,340,518,592.6</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,266,829,778.7</b>	<b>1,323,136,592.6</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,311,956,731.6	1,311,956,731.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-124,618,221.7	-146,448,566.1
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,390,000.0	15,390,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-2,565,000.0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,931,046.0	163,885,246.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,520,460.0	-41,627,599.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,285,012.0	63,285,012.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,594,329.1	-40,739,231.0
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>17,382,000.0</b>	<b>17,382,000.0</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	17,382,000.0	17,382,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>15,337,123,607.5</b>	<b>16,776,396,154.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>203,132,772.8</b>	<b>192,230,097.8</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>203,132,772.8</b>	<b>192,230,097.8</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>22,936,655.4</b>	<b>30,162,359.5</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	13,514,491.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,936,655.4	16,647,868.5
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>180,196,117.4</b>	<b>162,067,738.3</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	180,196,117.4	162,067,738.3
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,133,990,834.7</b>	<b>16,584,166,056.4</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>15,133,990,834.7</b>	<b>16,584,166,056.4</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	475,088,887.1	475,088,887.1
5E+05	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	475,088,887.1	475,088,887.1
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>14,647,782,851.4</b>	<b>16,097,958,073.0</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	12,719,101,490.4	14,627,943,911.0
51220	Тайлант үеийн үр дүн	1,928,681,361.0	1,470,014,162.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,119,096.3	11,119,096.3
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,337,123,607.5</b>	<b>16,776,396,154.2</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>69,455,366,465.4</b>	<b>95,189,361,976.7</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>36,073,975,008.8</b>	<b>38,806,803,846.7</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>36,073,975,008.8</b>	<b>38,806,803,846.7</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,975,645,797.4	26,856,667,359.9
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,390,592,704.6	2,811,564,191.2
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,583,504,175.0	1,898,003,042.7
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	450,713,718.9	533,640,944.1
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,673,518,612.9	6,706,928,308.8
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>63,137,525.6</b>	<b>184,527,178.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>63,137,525.6</b>	<b>184,527,178.0</b>
120002	Хүүгийн орлого	10,016,331.1	252,097.3
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>25,897,644.5</b>	<b>30,506,116.7</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,600,643.5	30,487,116.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	297,001.0	19,000.0
120009	Бусад орлого	1,783,550.0	127,088,964.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	25,440,000.0	26,680,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>33,318,253,931.0</b>	<b>56,198,030,952.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>0.0</b>	<b>9,549,630,710.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	9,549,630,710.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>285,000.0</b>	<b>14,400,000.0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.0	14,400,000.0
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>32,515,275,631.0</b>	<b>45,841,490,342.0</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,515,275,631.0	45,841,490,342.0
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>802,693,300.0</b>	<b>792,509,900.0</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	802,693,300.0	783,600,700.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.0	8,909,200.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>67,527,113,094.4</b>	<b>93,719,347,814.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>67,527,113,094.4</b>	<b>93,719,347,814.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>761,675,326.3</b>	<b>774,268,065.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>514,220,849.5</b>	<b>551,801,148.9</b>
210101	Үндсэн цалин	402,031,613.3	405,477,619.7
210102	Нэмэгдэл	83,307,237.0	84,927,392.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,041,999.2	33,203,999.8
210104	Урамшуулал	6,840,000.0	28,192,137.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>70,173,209.8</b>	<b>74,043,523.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,552,843.9	48,174,712.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,403,337.2	5,481,874.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,322,669.7	9,176,271.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,080,667.4	1,021,055.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,813,691.6	10,189,610.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,200,000.0</b>	<b>62,788,444.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.0	4,366,000.0
210302	Түлш, халаалт	56,500,000.0	54,109,144.0
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.0	4,313,300.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,560,700.0</b>	<b>19,014,750.6</b>
210401	Бичиг хэрэг	8,163,800.0	5,562,350.0
210402	Тээвэр, шатахуун	11,383,900.0	9,493,400.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,300.0	1,042,100.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	959,900.0	911,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,625,800.0	2,005,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.0</b>	<b>6,405,400.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.0	1,405,400.0
210604	Урсгал засвар	2,000,000.0	5,000,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,269,000.0</b>	<b>1,742,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	2,269,000.0	1,742,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>35,386,828.0</b>	<b>14,925,412.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,648,982.0	4,857,400.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.0	1,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500.0	33,000.0
210807	Газрын төлбөр	37,360.0	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,269,600.0	6,437,250.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,923,386.0	1,097,762.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,864,739.0</b>	<b>43,547,386.2</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,285,000.0	1,900,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,579,739.0	41,647,386.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,765,437,768.1</b>	<b>92,945,079,749.4</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,330,032,245.0</b>	<b>81,645,812,006.0</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,264,475,738.0	81,613,490,834.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,104,010.0	6,719,922.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,452,497.0	25,601,250.0
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,435,405,523.1</b>	<b>11,299,267,743.4</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,435,405,523.1	11,299,267,743.4
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,928,253,371.0</b>	<b>1,470,014,162.1</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>427,990.0</b>	<b>0.0</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	427,990.0	0.0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,928,681,361.0</b>	<b>1,470,014,162.1</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>116,642,671,229.0</b>	<b>95,373,331,586.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>34,436,350,531.9</b>	<b>38,151,467,277.5</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>34,436,350,531.9</b>	<b>38,151,467,277.5</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,227,352,936.4	26,399,132,609.9
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,990,663,478.7	2,765,150,571.7
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,233,885,626.7	1,866,607,801.6
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	375,614,769.7	524,305,873.0
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,608,833,720.4	6,596,270,421.4
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>120,949,647.8</b>	<b>150,634,909.4</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>120,949,647.8</b>	<b>150,634,909.4</b>
120002	Хүүгийн орлого	10,016,331.1	252,097.3
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>110,933,316.7</b>	<b>150,382,812.1</b>

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,636,315.7	150,363,812.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	297,001.0	19,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>82,085,371,049.3</b>	<b>57,071,229,400.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>84,829,400.0</b>	<b>10,481,060,500.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	84,829,400.0	10,481,060,500.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>285,000.0</b>	<b>14,400,000.0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.0	14,400,000.0
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>81,197,563,349.3</b>	<b>45,783,259,000.0</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,197,563,349.3	45,783,259,000.0
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>802,693,300.0</b>	<b>792,509,900.0</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	802,693,300.0	783,600,700.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.0	8,909,200.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>116,221,994,018.1</b>	<b>93,784,152,370.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>116,221,994,018.1</b>	<b>93,784,152,370.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>710,774,891.5</b>	<b>744,040,011.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>514,220,849.5</b>	<b>551,801,148.9</b>
210101	Үндсэн цалин	404,045,201.9	405,477,619.7
210102	Нэмэгдэл	81,293,648.4	84,927,392.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,041,999.2	33,203,999.8
210104	Урамшуулал	6,840,000.0	28,192,137.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,859,600.0</b>	<b>72,543,212.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,338,100.0	49,336,117.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,880,500.0	5,812,051.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,904,500.0	4,632,232.0
210204	Ажилгүйдлийн даатгал	976,000.0	1,163,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,760,500.0	11,599,612.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,200,000.0</b>	<b>62,015,300.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.0	4,366,000.0
210302	Түлш, халаалт	56,500,000.0	53,336,000.0
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.0	4,313,300.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,434,300.0</b>	<b>19,405,300.6</b>
210401	Бичиг хэрэг	8,163,800.0	5,582,900.0
210402	Тээвэр, шатахуун	11,383,900.0	9,493,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,427,300.0	1,042,100.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	959,900.0	911,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,499,400.0	2,375,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.0</b>	<b>20,805,400.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.0	15,805,400.0
210604	Урсгал засвар	2,000,000.0	5,000,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,269,000.0</b>	<b>1,742,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	2,269,000.0	1,742,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,506,142.0</b>	<b>13,827,650.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,648,982.0	4,857,400.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.0	1,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500.0	33,000.0
210807	Газрын төлбөр	37,360.0	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,269,600.0	6,437,250.0

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	42,700.0	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,285,000.0</b>	<b>1,900,000.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,285,000.0	1,900,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>115,511,219,126.6</b>	<b>93,040,112,358.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,388,558,274.2</b>	<b>81,740,844,615.4</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,299,432,488.8	81,614,421,753.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,104,010.0	6,719,922.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,569,278.4	94,101,690.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,452,497.0	25,601,250.0
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>55,122,660,852.5</b>	<b>11,299,267,743.4</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,122,660,852.5	11,299,267,743.4
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>420,677,210.9</b>	<b>1,589,179,216.2</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>420,677,210.9</b>	<b>1,589,179,216.2</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,065,314,749.7	6,485,991,960.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,485,991,960.6	8,075,171,176.7

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	12,685,030,490.4	13,171,238,473.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	34,071,000.0	34,071,000.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	12,719,101,490.4	13,205,309,473.7
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	1,928,681,361.0	1,928,681,361.0
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	14,647,782,851.4	15,133,990,834.7
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	14,647,782,851.4	15,133,990,834.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-19,838,940.4	-19,838,940.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	14,627,943,911.0	15,114,151,894.3
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	1,470,014,162.1	1,470,014,162.1
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	475,088,887.1	11,119,096.3	16,097,958,073.0	16,584,166,056.4

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,970,138,600.0	82,376,363,015.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,970,138,600.0	82,376,363,015.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,887,600.0	729,640,011.9

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>584,021,000.0</b>	<b>551,801,148.9</b>
210101	Үндсэн цалин	420,006,800.0	405,477,619.7
210102	Нэмэгдэл	92,685,400.0	84,927,392.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,576,800.0	33,203,999.8
210104	Урамшуулал	30,752,000.0	28,192,137.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>73,002,600.0</b>	<b>72,543,212.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,641,800.0	49,336,117.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,840,200.0	5,812,051.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,672,200.0	4,632,232.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,168,100.0	1,163,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,680,300.0	11,599,612.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,015,300.0</b>	<b>62,015,300.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,366,000.0	4,366,000.0
210302	Түлш, халаалт	53,336,000.0	53,336,000.0
210303	Цэвэр, бохир ус	4,313,300.0	4,313,300.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,816,800.0</b>	<b>19,405,300.6</b>
210401	Бичиг хэрэг	5,582,900.0	5,582,900.0
210402	Тээвэр, шатахуун	10,628,000.0	9,493,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,318,900.0	1,042,100.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	912,000.0	911,900.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.0	2,375,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,405,400.0</b>	<b>6,405,400.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,405,400.0	1,405,400.0
210604	Урсгал засвар	5,000,000.0	5,000,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,232,400.0</b>	<b>1,742,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	2,232,400.0	1,742,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,494,100.0</b>	<b>13,827,650.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,857,400.0	4,857,400.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.0	1,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.0	33,000.0
210807	Газрын төлбөр	100,000.0	0.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,836,700.0	6,437,250.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,900,000.0</b>	<b>1,900,000.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.0	1,900,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,200,251,000.0</b>	<b>81,646,723,003.4</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>82,200,251,000.0</b>	<b>81,646,723,003.4</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	82,165,982,000.0	81,614,421,753.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,985,000.0	6,700,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,284,000.0	25,601,250.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>82,970,138,600.0</b>	<b>42,152,953,288.3</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>10,481,060,500.0</b>	<b>10,481,060,500.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	10,481,060,500.0	10,481,060,500.0
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>72,489,078,100.0</b>	<b>31,564,358,153.4</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	72,480,168,900.0	31,555,448,953.4
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,909,200.0	8,909,200.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.0</b>	<b>107,534,635.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	107,515,635.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	19,000.0

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,485,991,960.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	8,075,171,176.7
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>93.0</b>	<b>89.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>46.0</b>	<b>44.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	37.0	37.0
620003	Үйлчлэх ажилтан	8.0	6.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>46.0</b>	<b>44.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	38.0	34.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0	10.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,400,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,400,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,400,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,400,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,400,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,400,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,400,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,400,000.0

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийгмийн даатгалын байгууллагын стратеги зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг даатгуулагчдад олгон тэдний нийгмийн баталгааг хангахын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Тус хэлтэс нь:

- Үйлчилгээний тасаг
- Санхүү бүртгэлийн тасаг
- Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг
- Булган сумын нийгмийн даатгалын тасаг гэсэн 4 тасаг, 46 орон тоо, бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл 80-жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний заалтуудыг мөрдлөг болгон ажиллаж аймгийн хэмжээнд 13195 тэтгэвэр авагчийн тэтгэврийг сар бүр бүрэн олгосон.

Монгол улсын засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож уг тогтоолыг хэрэгжүүлэхэд 350.0 мянгаас дээш төгрөгийн тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг тэтгэврийн доод хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд нэмэгдлийн хэмжээ нь 15 хувьд хүрэхгүй байгаа иргэдийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэхээр тогтоол гарсантай холбогдуулан 2022 оны хоёрдугаар сарын

тэтгэврийг нэмэгдсэн хэмжээгээр олгох ажлыг шуурхай зохион байгуулан нийт 12480 тэтгэвэр авагчдад 1,626.0 сая төгрөгийн нэмэгдлийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр бүрэн хийж тэтгэвэр авагчдад олгосон. Үүнээс 7067 тэтгэвэр авагчдад 150.0 мянган төгрөг, 3836 тэтгэвэр авагчдад 15 хувиар, 1577 тэтгэвэр авагчдад хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр нэмэгдүүлсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн тушаал заавар журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилласан байна. Ховд аймгийн Жаргалант сумын нийт төсөвт байгууллага болон ААН байгууллагын 120 нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан нарт сургалт зохион байгуулсан. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, Нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд нь нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх, шимтгэлийн авлага, өглөг үүсэхээс урьдчилан сэргийлэх болон нийгмийн даатгалын хуульд орсон нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээ, 2022 оноос эхлэн эмнэлгийн хуудас цахим системд шилжсэн талаар сургалт зохион байгуулж, заавар зөвлөмж өгсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь журмын дагуу ажиллаж 2 удаа хуралдаж дүгнэлт гаргасан.

Тус хэлтэс 74 нэр төрлийн 346 ширхэг 13306252.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй бөгөөд үндсэн хөрөнгийн тооллогыг энэ онд 3 удаа хийж тооллого хийлээ. 2022 онд сумдын байцаагч нарт 14.4 сая төгрөгийн 18 ширхэг олон үйлдэлт принтер, 33.3 сая төгрөгийн үнэ бүхий 15 ш суурин компьютер 15 ш тог баригч, 8 ширхэг зөөврийн компьютер хүлээн авсан.

Хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/15, 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/33 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын дагуу "Тэтгэвэр тогтоож, олгох үйлчилгээний заавар"-ын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж шалгаж баталгаажуулсан. Тооллогод 17 сумын 13759 тэтгэврийн хувийн хэрэг хамрагдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,439.2 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,485,992.0	8,075,171.2	1,589,179.2
Авлага	7,563,149.0	7,356,285.6	-206,863.4
Бараа материал	3,770.9	4,420.8	649.9
Үндсэн хөрөнгө	1,284,211.8	1,340,518.6	56,306.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,337,123.6</b>	<b>16,776,396.2</b>	<b>1,439,272.6</b>
Өр төлбөр	203,132.8	192,230.1	-10,902.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>15,133,990.8</b>	<b>16,584,166.1</b>	<b>1,450,175.3</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>15,337,123.6</b>	<b>16,776,396.2</b>	<b>1,439,272.6</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,075.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 1,589.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Тайлант онд нийт авлага 49,310.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 49,517.8 сая төгрөгөөр хорогдож зөрүүгээр нь 206.8 сая төгрөгөөр буурсан байна.
- Бараа материал 3.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 4.4 сая төгрөгөөр буурч 0.6 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны байгууллагын үйл ажиллагааны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 973.9 сая, урсгал зардлыг 973.9 сая төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн орлогыг 29,260.7 сая төгрөгөөр, нийт сангийн зарлагыг 66,383.2 сая төгрөгөөр, зөрүүгээр нь санхүүжилт авахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал 794.3 сая, нийгмийн

даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 34,201.9 сая, зарлагын төлөвлөгөө 63,785.8 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 2022 оны төсвийн хуваарь баталж, мөн зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны 05 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/192 дугаар тушаалаар 2022 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж тодотгол хийсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл 755.5 сая төгрөг, 36.9 сая төгрөг хэмнэсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 31,555.0 сая төгрөг буюу 108 хувиар биелүүлж ажилласан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага тэтгэврийн даатгалын сангаас 14028 тэтгэвэр авагчид 78,174.9 сая, тэтгэмжийн даатгалын сангаас 2640 даатгуулагчид 2,626.2 сая, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 47 тэтгэвэр тэтгэмж авагч иргэнд 267.6 сая, ажилгүйдлийн даатгалын сангаас 293 даатгуулагчид 531.9 сая төгрөг хийтдээ 17008 иргэнд 81,600.6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж тавьж олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 82,376.3 сая төгрөг 99.3 хувьтай байгаа бөгөөд үйл ажиллагааны зардлаас хэмнэгдсэн 36.9 сая төгрөгийг төвлөрүүлж, сангийн дансны үлдэгдэл 8,075.2 сая төгрөг байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	Нийгмийн даатгалын хэлтэс /Цалин болон нэмэгдэл урамшил/ 71901/80101	584,021.0	551,801.1	32,219.9	94.5
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 71901/80101	73,002.6	72,543.2	459.4	99.4
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 71901 /80102	62,015.3	62,015.3	0.0	100.0
4	Хангамж, бараа материалын зардал 71901/80103	20,816.8	19,405.3	1,411.5	93.2
5	Эд хогшил, урсгал засварын зардал 71901/80101	6,405.4	6,405.4	0.0	100.0
6	Томилголт, зочны зардал 71901/80101/210702	2,232.4	1,742.0	490.4	78.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 71901/80103	19,494.1	13,827.6	5,666.5	70.9
8	Хичээл үйлдвэрлэлийн дадлага Сургалт семиннар 71901/80101/210902	1,900.0	1,900.0	0.0	100.0
9	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж 71901/140020	82,165,982.0	81,614,421.7	551,560.3	99.3

10	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 71901/80802	7,985.0	6,700.0	1,285.0	83.9
11	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 71901/80813	26,284.0	25,601.2	682.8	97.4
	<b>Дүн</b>	<b>82,970,138.6</b>	<b>82,376,362.8</b>	<b>593,775.8</b>	<b>99.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас аймгийн нийгмийн даатгалын мэдээллийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх 14.4 сая төгрөгийг бүрдүүлж, Женералтеч ХХК-наас 18 ширхэг принтер худалдан авах зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 02 дүгээр сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 77 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 93,719.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 937.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 656.0 сая төгрөгөөр тогтоосон.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.*

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 актын төлбөрийг бүрэн барагдуулж, Нийгмийн даатгалын сангийн насжилт өндөртэй авлагыг барагдуулах тухай 25.6 сая төгрөгийн нэг зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар 206.8 сая төгрөгийн авлага барагдсан байна. Ажилтан албан хаагчдын албан хэрэгцээнд зарцуулсан авто машинд олгосон шатахууны жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй, зарим явсан албан хаагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, замын хуудас дутуу 7.9 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж тайлант онд шатахууны зардлыг 1.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах тухай зөвлөмж өгөгдсөнд тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой уг хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй тул зөвлөмжийн биелэлт хангагдсан гэж дүгнэхээр байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,482.1	1	1,482.1	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	3	79,100.0	3	79,100.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>80,582.1</b>	<b>4</b>	<b>80,582.1</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдсэнгүй.

Аудитаар нэгтгэсэн тайлангаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны тайлангаар нийт 4,762.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 4,762.0 төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.2 Зөвлөмж

1. Санхүүгийн анхан шатны баримттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сургалтын зардал, материалын үнэ, сэлбэгийн үнэ, ахмадын сангийн зардал, ахмадын урамшуулал гэх мэт нийт 4.8 сая төгрөгийн зардлын санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, зардлыг санхүүжүүлэхгүй байх. Анхан шатны баримтуудыг иж бүрэн бүрдүүлж ажиллах

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан туш	Тоо	Дүн
Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй	1	4,762.0					1	4,762.0	0	0	0	0
Дүн	1	4,762.0	0	0	0	0	1	4,762.0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Ц.АЗЗАЯА

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.